



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Арбитр дахь өмгөөлөгчийн оролцоо, үүрэг, хариуцлага

МӨХ-ны Мэргэжлийн хариуцлагын
хорооны гишүүн, өмгөөлөгч Д.Оросоо



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Өмгөөлөгчид арбитрын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Уламжлалт шүүхийн тогтолцооноос гадуур маргааныг шийдвэрлэх тогтолцоо, процесст үйлчлүүлэгчдийнхээ эрх, ашиг сонирхлыг хамгаалах, арбитраас оновчтой шийдвэр гаргахад чухал үүрэг, оролцоотой байдаг.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Эх сурвалж:

- 1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
- 2.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм
- 3.Өмгөөллийн тухай хууль
- 4.Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм
- 5.Өмгөөллийн үйл ажиллагааны нэгдсэн шаардлага



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



**Өмгөөлөгч нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиж
ажиллах үүрэгтэй:**

1. Нууц хадгалах

Үйлчлүүлэгчийн болон хуралдаан, өмгөөллийн нууц хадгалах

ӨТХ-ийн 25 дугаар зүйлд үйлчлүүлэгчид үзүүлж буй мэргэжлийн туслалцаа,
тэдгээрийн харилцаатай холбоотой бүхий л баримт сэлт, мэдээлэл

2. Ур чадвартай байх

Хууль зүйн мэдлэгээ практикт хэрэглэх чадвар, дадал болгон хөгжүүлсэн байх,
хэрэглэх хууль, дүрэм, журмын судалсан, мэдээлэлтэй байх



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



3. Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх

Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчээ шударга, үр дүнтэй төлөөлөх, өмгөөлөгч байдалд сөргөөр нөлөөлөх зөрчлөөс зайлсхийх ёстой.

Ашиг сонирхлын зөрчлийг Өмгөөлөгчийн Мэргэжлийн ёс зүйн дүрмийн 19, 20 дугаар зүйлд нарийвчлан заасан.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



4.Хичээл зүтгэл гаргах, цаг баримтлах

Өмгөөлөгч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах, хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллана.

5.Харилцаа холбоо

Аливаа шийдвэр, нөхцөл байдлын талаар, хууль зүйн үйлчилгээний арга, зорилго, ажлын явц, үйлчлүүлэгчийн хүсэлтэд шуурхай хариу өгөх, харилцаа холбоотой байх



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



6. Шударга ёс ба ёс суртахуун

Өмгөөлөгч нь шударга ёсны хамгийн дээд стандартыг баримтлан ажиллах, үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөх үүрэгтэй.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



7. Эрх зүйн тогтолцоог хүндэтгэх

Хууль, дүрэм, журмыг хүндэтгэх, шүүх, арбитрын эрх мэдлийг хүлээн зөвшөөрөх, зүй бусаар нөлөөлөх, шийдэр гаргасных нь төлөө сайшаах, буруушаах ёсгүй

8. Төлөөлөл ба өмгөөллийн үйлчилгээ

Өмгөөлөгч нь нотлох баримт гаргаж, хууль зүйн үндэслэлтэйгээр маргаж, үйлчлүүлэгчийн байр суурийг хамгаалах замаар үйлчлүүлэгчээ төлөөлнө.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



9. Арбитрын үйл явцыг хүндэтгэх

Өмгөөлөгч нь арбитрын дүрэм, арбитрчийн эрх мэдлийг хүндэтгэж, хурал, процессыг шударга, үр ашигтай, хүндэтгэлтэй явуулахад хувь нэмрээ оруулна, арбитрын шийдвэрийг мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрнө.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



10. Үндэслэлтэйгээр итгэх

Тодорхой нөхцөл байдалд өмгөөлөгч өөрийн бодит итгэл дээр тулгуурлан мэргэжлийн үйл ажиллагаа явуулж, үүнийгээ үндэслэлтэйгээр тайлбарлах

11. Мэдээлэлтэй зөвшөөрөл

Өмгөөлөгчөөс санал болгосон үйл ажиллагаанаас үүсэж болох эрсдэл, хууль зүйн үр дагавар болон бусад хувилбарын талаар хангалттай мэдээлэл, тайлбар өгснөөр үйлчлүүлэгч тухайн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн илэрхийлэл



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



12.Хараат бус байх

Аливаа зүй бус нөлөөлөл, эсхүл хяналтаас ангид байх

13.Зохисгүй байдал гаргахгүй байх

Хууль, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, ёс зүйн дүрэм зөрчсөн, өмгөөлөгчийн хараат бус, зарчимч байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүй



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



14. Өмгөөлөгчийн мэргэжлийн үүргээ чухалчлах

Өмгөөлөгч нь мэргэжлийн үүргээс бусад үйл ажиллагаа болон хувийн амьдралдаа мэргэжлийн үүрэгтэйгээ зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ.

15. Хувийн дотно харилцаанаас зайлсхийх

Хувийн дотно харилцаанаас зайлсхийх, ийм харилцаа үүссэн бол үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



16. Мэдээлэл хийхдээ дүрэм зөрчихгүй байх, олон нийттэй харилцах хэм хэмжээ

Өмгөөлөгч нь мэргэжлийн үүрэгтэй холбоотой худал, төөрөгдүүлсэн агуулгатай, мэргэжлийн нэр хүндийг гутаасан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх мэдээлэл хийхийг хориглоно.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА